

**“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-Г ГАЛИГЛАХ ХЯТАД ҮСГИЙГ
ХЭРХЭН СОНГОСОН, ТҮҮНИЙ ОНЦЛОГ**

М.Жавхлан

Монголчуудын хэл, түүх, соёлын агуу их дурсгал “Монголын нууц товчоо”-г дэлхийн олон хэлэнд орчуулжээ. Эл гайхамшигт бүтээлийг анх Монгол нутагт авьяас билигт монгол бичээч монгол хэл, бичгээрээ туурвисан нь эргэлзээгүй юм. Гэвч эдүгээ анхны тэрхүү монгол бичгийн эх үрэгдэн үгүй болоод Мин улсын сударч түшмэдийн хятад хүнд монгол хэл сургах сурах бичиг, толь бичиг болгох зорилгоор хятад үсгээр галиглан үг бүрийг нь хятадаар дор дор нь хадаж, зүйл бүрийн эцэст гол санааг нь товчлон орчуулсан хэд хэдэн хуулбараар л бидэнд уламжлан ирсэн билээ.

Монголчууд түүхэн явцдаа олон арван сурвалж бичгийг бүтээн туурвиж байсан боловч уг сурвалж бичгүүдийн язгуур нь Монголын нууц товчоотой ямар нэгэн хэмжээгээр холбогддог. Иймээс Монголын нууц товчоог авиалан галигласан хятад сурвалж, түүн доторх ханз үсгүүдийг судлах нь нэн чухал юм.

Энэхүү өгүүлэлд Монголын нууц товчооны дэвсгэр үсэг, түүнийг галиглахад хэрэглэсэн ханз үсгийг хэрхэн сонгосон, мөн тэдгээр үсгийн онцлог, тогтолцоог харуулахыг зорилоо.

**“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ
ХАНЗ ҮСГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ**

Мин улсын Юнлэ хуанди (1402-1424)-ийн үед буюу 1403-1407 онд эмхэтгэсэн “Юнлэ да диэн” (永樂大典) хэмээх тухайн үеийн утга зохиолын бараг бүхий л бүтээл туурвилыг хамарсан их цоморлогт Монголын нууц товчооны нангиад орчуулга анх багтан орсноос үзэхэд 1400-аад оны эхэн гэхэд Монголын нууц товчоог нангиадаар галиглаж, хадмал болон утгачилсан орчуулгыг бүрэн дуусгасан ажээ. Хятад галиг, хажуугийн орчуулга, ерөнхий орчуулга хийсэн ба Манж Чингийн үед “Монголын нууц товчоо” судлал нь нэлээд өргөн хэмжээнд явагдаж, энэ үеэс эхэлж чухал түүхэн судар бичигт тооцогдож түүгээр төв судрын агуулгыг нөхвөрлөж болохуйц хэмжээнд хүртэл үнэлэгдсэн бөгөөд судалгааны хүрээ хэмжээ нь голдуу ном хадгалагч, бар барлагч, харгуулан хянагч нараар голлосон бичгийн эрдэмтнээс оршил, гаргалгаа, цохолбор, агуулгын товч бичих, жич “Монголын нууц товчоо”-ны агуулга ба үнэ цэн, бар хэвлэлийн цаг хугацаа, хэрхэн бичсэн арга, ботийн тоог танилцуулах хүрээнд явагдаж байжээ.

Японы монголч эрдэмтэн Ш.Озава: Монгол хэлний хамгийн бага үе бол

1. SVC¹ - Үгийн эхний С нь тэг болоход хүрвэл VC, үгийн эцсийн С нь тэг болоход хүрвэл CV болно. Үгийн эхний ба эцсийн гийгүүлэгч нь бүгд тэг болоход хүрвэл V болдог гэж үзжээ. Жишээлбэл, *bab* (CVC) гэсэн үгийн эхний гийгүүлэгч нь тэг болбол *ab* (VC), харин эцсийн гийгүүлэгч нь тэг болоход хүрвэл *ba* (CV), эхэн ба сүүл нь бүгд тэг болоход хүрвэл *a* (V) болно.

¹ С нь гийгүүлэгч, V нь эгшиг илтгэнэ.

2. Монголын нууц товчоонд *aqa* “ах”-ыг 啊^中合 гэж хятад үсгээр галиглаж байна. Гэвч 中^中合-ийн 中 нь юу вэ гэвэл XIV зууны сүүлийн хагасын хятад хэлний умардын аялгуунд хэлний хойгуурх зөөлөн тагнайн хамжих гийгүүлэгч [q] байгаагүй болохоор тухайн үеийн хятад хэлэнд байсан хэлний хойгуурх зөөлөн тагнайн шүргэх гийгүүлэгч [x]-тэй үсгийн зүүн талын дээр хэсэгт жижиг 中 үсэг тавьж монгол хэлний хэмжих гийгүүлэгч [q] эсвэл [g]-г илтгэжээ. *garga* “гарга”-ыг 中^中合^合兒^兒合 гэхэд энд бас жижгээр 舌 үсэг гарч байна. Энэ нь хятад хэлэнд байхгүй тохирох гийгүүлэгч [r]-ийг илтгэж, 兒 гэдэг үсэг нь зөвхөн гийгүүлэгч [r] болсон байна (Озава, 1998:140-142).

Эрдэмтэн Шонхор “Монголын нууц товчоо”-д тохиолдож байгаа хятад үсгийг жагсаан бичихдээ жижиг 舌, 中 хадсан үсгүүдийг тусдаа үсэг хэмээн үзэж ангилжээ. Үүнд, гийгүүлэгч хятад үсгийн өмнө жижиг 舌 үсэг хадсан нь *r* гийгүүлэгч болохыг илэрхийлэн, *h* гийгүүлэгчид хятад үсгийн өмнө жижиг 中 үсэг хадсан нь *q* гийгүүлэгч болохыг илэрхийлсэн. Гэхдээ тэг гийгүүлэгч хятад үсгийн өмнө хааяа жижиг 中 үсэг хадсан нь адил нөхцөл дэх жижиг 中 хадаагүй үсгийн дуудлагатай адил *h* гийгүүлэгчийг тэмдэглэсэн бололтой бөгөөд *k* буюу *g* гийгүүлэгчид хятад үсгийн өмнө жижиг 中 үсэг хадсан нь тус тус *q* авиалбарын хувилбар *kh*, *gh* гийгүүлэгчийг илтгэсэн бололтой. Үүнээс гадна хятад үсгийн доод талд жижиг үсэг 卜, 赤, 乞克, 惕, 力泐勒, 木你, 黑, жижиг бус үсэг 失室, 儿而 усны түшлэгт 而 үсэг, уулын түшлэгт 而 үсэг, 思 зэрэг үсгээр тус *b*, *č*, *k* (*g*), *t* (*d*), *l*, *m*, *n*, *x*(*q*), *š*, *r*, *s* зэрэг дэвсгэрийг тэмдэглэсэн байна (Шонхор, 2002:22).

舌, 中 ТЭМДГИЙГ НЭМЭЛТЭЭР АВЧ ХЭРЭГЛЭСЭН ГАЛИГ ҮСЭГ

Хятад үсэгт нэмэгдэл тэмдэг хэрэглэж монгол үгийг галигласан байна. Нэмэгдэл тэмдэг нь 舌, 中 гэсэн хоёр зүйл бөгөөд үндсэн үсгийн зүүн дээд талд жижгээр бичихэд 舌 тэмдэгтэй байвал хэлний чичрэх *r*-ээр ялган унших гэсэн санааг. *er* гэсэн дуудлагатай 兒 ийн өмнө 舌 тэмдэг тавьж тодолсон байдаг. Энэ нь хятад хэлний *er*-ийн дуудлага монгол хэлний *r* –ийн дуудлагатай тохирохгүй гэсэн үг бөгөөд нөгөө талаар Монголын нууц товчооны үг, авиалбар бүрийг хятадаар хэрхэн нарийн тодорхой галигласныг харуулна. Жишээлбэл:

中^中合^合撒^撒兒^兒 *qasar*

朵^朵兒^兒邊^邊 *dörben*

字^字兒^兒 *bor*

中^中忽^忽兒^兒班^班 *qurban*

篋^篋兒^兒乞^乞帖^帖 *merkit-te*

Монголын нууц товчоонд тусгай тэмдэг бүхий үсэг нийт 65 буй бөгөөд түүнээс 舌 тэмдэгтэй үсэг 41 байна. Тэдгээр нь:

№	МНТ дахь 舌 тэмдэгт үсэг	Дуудлага	МНТ дахь энгийн хэлбэр	Дуудлага
1	舌列	re	列	le
2	舌理	ri	理	ri
3	舌闌	ra, ran	闌	lan, ral
4	舌漣	ren	漣	len
5	舌里	ri	里	li
6	舌羅	ro	羅	ro, lo
7	舌騾	ro		
8	舌刺	ra	刺	la
9	舌目刺	ra	目刺	ra
10	舌魯	ru, rü	魯	lū, l, lu
11	舌論	rün		
12	舌劣	rö	劣	lō
13	舌良	riang	良	leng
14	舌藍	rom		
15	舌侖	rün	侖	lun
16	舌連	ren	連	len
17	舌鄰	rin	鄰	rin
18	舌麟	rin	麟	rin
19	舌籃	ram		
20	舌驪	ri	驪	ri
21	舌林	rim	林	rim
22	舌樂	ron	樂	lon
23	舌来	rai	来	lai
24	舌兒	r	兒	er
25	舌廉	rem		
26	舌洌	ren	洌	ren
27	舌怜	ren		
28	舌澧	ri		
29	舌沔	r	沔	er
30	舌瀧	rün		
31	舌輪	rün		
32	舌芳	rö		
33	舌岨	r	岨	er
34	舌籠	rüng	籠	lung
35	舌離	ri		

36	𠬞路	ru		
37	𠬞馬羅	ro		
38	𠬞零	ring	零	ling
39	𠬞𠬞	rü		
40	𠬞𠬞	ri		
41	𠬞𠬞	ra		

^中 тэмдэгтэй бол хэлний угийн гийгүүлэгч, эсвэл амьсгалын түрэлттэй дуудна гэсэн үг. Монголын нууц товчооноо ^中 тэмдэгтэй үсэг 24 байх ба тэдгээр нь:

	МНТ дахь ^中 тэмдэгт үсэг	Дуудлага	МНТ дахь энгийн хэлбэр	Дуудлага
1	^中 豁	qo	豁	qo
2	^中 兀	'u	兀	'u, 'ü
3	^中 合	qa	合	qa
4	^中 忽	qu	忽	hu, qu, hü
5	^中 罕	qan	罕	han, qan
6	^中 渾	qun	渾	qun
7	^中 含	qam	含	hem
8	^中 灰	qui		
9	^中 昆	qun	昆	gün, güm
10	^中 荒	qong		
11	^中 海	qai		
12	^中 晃	qong	晃	qong
13	^中 康	kang	康	kang
14	^中 火	qo	火	ho
15	^中 窟	ku	窟	kü
16	^中 鶻	qun		
17	^中 崑	kun, qun		
18	^中 孩	qai	孩	qai
19	^中 棍	gün	棍	gün
20	^中 翁	ong	翁	ong, ung
21	^中 闊	kö	闊	kö
22	^中 窟	ču		
23	^中 恰	qa		
24	^中 干	qan		

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООГ ГАЛИГЛАХАД ДЭВСГЭР ҮСГИЙГ ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ

Хятад үсгийн энгийн хэлбэрийг албаар жижгэрүүлж, мөрийн баруун доод талд харагдахуйц тод бичсэн байдаг нь тусгай учиртай. Дэвсгэр үсэг гэдгийг таниулж тэмдэглэн, хятад хэлтэй хүнд зөв уншуулахын тулд юм. Нөгөө талаар энэ нь, хэдийгээр Монголын нууц товчооны уугал эх нь хараахан олдоогүй байгаа боловч хятад үсгээр галиглах цагт эх болгож ашигласан Монголын нууц товчооныг бичсэн үсэгт дэвсгэрлэх ёсыг хатуу баримталдаг байсныг бидэнд тов тодорхой харуулж байна.

Монголын нууц товчоонд жижиг хэлбэртэй байх ёстой атал жижгээр бичээгүй ^舌兒, ^舌湏, ^舌岫 гурван үсэг буй.

Монголын нууц товчоон дахь үндсэн хэлбэр ба дэвсгэр үсгийн дуудлага өөр. Үндсэн хэлбэрийн арын эгшгийг дуудах ба дэвсгэр үсгийн арын эгшгийг бараг дуудахгүй. Түүнийг мэдрүүлэхийн тулд Монголын нууц товчоог галигласан эрдэмтэд том, жижиг үсгүүд ба байршлаар (баруун доод өнцөгт) ялгаж өгсөн байна. Монголын нууц товчооны хятад галиг маш нарийн тогтолцоотой болохыг монгол дэвсгэр үсгийг хэрхэн зөв галигласнаар харуулж байна. Доор Монголын нууц товчоонд гарч байгаа дэвсгэр үсгүүдийг энгийн хэлбэртэй нь зэрэгцүүлэн харуулья.

Дэвсгэр үсгийн хүснэгт:

克	k	克	kei
勒	l	勒	le
黑	q	байхгүй	
惕	d, t	байхгүй	
卜	b	卜	bu
木	m	木	mü, mu
赤	č	赤	či
思	s	思	s
勸	l	байхгүй	
你	n	你	ni
室	s	байхгүй	
先	š	先	sen
边	l	байхгүй	
乞	k	乞	ki
^舌 湏	r	湏	er
^舌 岫	r	岫	er
^舌 兒	r	兒	er

Монголын нууц товчоонд 赤 [č] дэвсгэр үсэг нь mōčqiju 02:26:06 (ᠮᠣᠴᠠᠵᠢᠵᠢ) mōčqiqed 02:26:07 (ᠮᠣᠴᠠᠵᠢᠵᠢᠭᠡᠳ) үгэнд тохиолдож байна. Энэ нь монгол бичгийн хэлний mōsqiju (ᠮᠣᠰᠠᠵᠢᠵᠢ), mōsqiqed (ᠮᠣᠰᠠᠵᠢᠵᠢᠭᠡᠳ) гэсэн үг болно. Уг нь монгол бичгийн зөв бичих зүйн дүрмээр бол s дэвсгэр орох учиртай. Монголын нууц товчоог галигласан хүн č аялгуутан байх боломжтой юм.

1. -s дэвсгэрийг Монголын нууц товчоонд дараах дөрвөн янзын үсгээр тэмдэглэсэн байна (思, 先, 室, 赤)

思 дэвсгэр нь монгол бичгийн хэлний -s, -s-тэй тохирно. Нийтдээ Монголын нууц товчоог галиглахад 思 том хэлбэрээр дунд орсон дэвсгэрт 101 үг, адагт орсон 107 үг байна. 思 жижиг хэлбэрээр дунд орсон 2 үг, адагт орсон 8 үгэнд хэрэглэсэн байна.

先 дэвсгэр нь монгол бичгийн хэлний -s- тэй тохирно. Монголын нууц товчоонд үгийн дунд орсноор тэмдэглэсэн нэг үг буй. Östü ᠥᠰᠲᠦ 05:01:10 斡先秃 хэмээн гарч байна.

室 дэвсгэр нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний -s- тэй тохирно. Монголын нууц товчоонд qosduriyan 05:49:10 豁室都里顏 хэмээн нэг удаа гарч байна.

2. 兒 дэвсгэр -r-, -r хааяа ru, ri тохирдог. Монголын нууц товчоонд дунд орсон 725 үг, адагт орсон 318 үг буй.

兒 дэвсгэр үсэг нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний -r- тэй тохирдог. 兒 er-ээр тэмдэглэсэн дэвсгэр 6 үг байна. erhi, örnekü, burqi, burqan-i, burqan-a, burqan.

洎 дэвсгэр үсэг нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний -r- тэй тохирдог. 洎 er-ээр тэмдэглэсэн дэвсгэр 5 үг байна.

額洎古涅 ergüne (3)

額洎古涅迭 ergüne-de (1)

豁洎合訥 _qorqan-u (1)

3. -k-, -k дэвсгэрийг Монголын нууц товчоонд 克, 黑, 乞 гурван янз ханз үсэг оруулан тэмдэглэсэн байна.

克 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний -k-, -k тэй тохирдог. Монголын нууц товчоонд дунд орсон 262 үг, адагт орсон 36 үг байна.

黑 нь Монголын нууц товчооны монгол бичгийн хэлний -q-, -q тэй тохирно. Монголын нууц товчоонд 黑-ээр тэмдэглэсэн дэвсгэр 413 үг, адагт орсон 76 үг байна.

Дэвсгэр 乞 нь Монголын нууц товчооны монгол бичгийн хэлний -k- тэй тохирдог. Монголын нууц товчоонд дунд орсон 1 үг буй. 乞 дэвсгэр үсэг чухам ямар үгэнд орсныг харвал: nökčiyedkün ᠨᠥᠵᠢᠶᠡᠳᠦᠭᠦᠨ

4. -l-, -l дэвсгэр Монголын нууц товчоонд 勒, 沏, 泐 гурван янз үсгээр тэмдэглэсэн байдаг:

Дэвсгэр 勒 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний -l-, -l тэй тохирдог. Монголын нууц товчоонд дунд орсон 1052 үг, адагт орсон 124 үг байна.

Дэвсгэр 沏 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний -l- тэй тохирдог. Монголын нууц товчоонд 沏-ээр дэвсгэрлэсэн үгийн дунд орсон нэг л үг байна.

Qariltu 哈 禮 秃 ᠬᠠᠷᠢᠯᠲᠤ 04:18:02

Дэвсгэр 𐪞 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний *-l-*, *-l* тэй тохирдог. Дунд орсон 5, адагт орсон 3 үг байна.

5. Дэвсгэр 𐪟 Монголын нууц товчоонд нэг энэ үсгээр тэмдэглэсэн байдаг. 𐪟 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний *-d-*, *-d*, *-t* тохирдог. Дунд орсноор тэмдэглэсэн *-d-* дэвсгэрт 316, адагт орсон 387 үг буй.

6. Дэвсгэр 𐪠 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний *-b-*, *-b*-тэй тохирно. Монголын нууц товчоонд дунд орсон 𐪠-ээр тэмдэглэсэн *-b-* дэвсгэрт 185 үг, адагт 8 үг байна.

7. Дэвсгэр 𐪡 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний *-m-*, *-m*-тэй тохирно. Монголын нууц товчоонд үгийн дунд орсон 𐪡-ээр тэмдэглэсэн *-m-* дэвсгэртэй 21 үг, адагт 6 үг байна.

8. *-n-*, *n-* дэвсгэрийг Монголын нууц товчоонд 你 *ni* гэсэн нэг л үсгээр тэмдэглэсэн байна. Дэвсгэр 你 нь Монголын нууц товчоонд монгол бичгийн хэлний *-n-*, *n-* тохирч байна. Монголын нууц товчоонд үгийн дунд орсон 你-ээр тэмдэглэсэн *-n-* дэвсгэрт үг 7 байна.

ДҮГНЭЛТ

“Монголын нууц товчоо”-ны хэлийг олон талаас нь, хэлний олон төвшинд судлах ажил эрчимтэй болжээ. “Монголын нууц товчоо”-ны үг хэллэг, зарим өгүүлбэр, эхийн зарим хэсэг, зарим үгийн үгийн сангийн утга, үг бүтээх дагавар, үг хувилгах нөхцөл зэргийг улам бүр тогтолцоотой судлахын хамт гадаад хэлээр орчуулах, эрдэм шинжилгээний шинэ латин галиг хийх, анхны монгол бичгийн эхийг тухайн үеийн үсгийн тиг, зөв бичих ёс, хэлзүйн онцлогоор нь сэргээх, орчин цагийн монгол хэлэнд дахин хөрвүүлж, эртний үг хэллэгийн тайлбар хийх, хожмын монгол түүхэн сурвалжуудтай эх бичиг судлалын үүднээс харьцуулах гэх мэт судалгаа үргэлжлэн хийгдэж, судалгааны чанарын төвшин ч сайжирчээ.

Судлаачид “Монголын нууц товчоо”-ны хэлийг судлахдаа монгол үгийг хятад үсгээр галигласан эх, түүний хятад орчуулгад л гол анхаарлаа тавьж хандуулдаг байсан билээ. Өдгөө эрт болон дунд үеийн монгол хэл, монгол хүний хэл сэтгэхүйн онцлогийг анхаарч, “Монголын нууц товчоо”-ы анхны уйгуржин бичгийн эхэд тухайн үг ямар онцлогтой бичигдсэн байж болох вэ?, тийм өвөрмөц онцлогтой эхийг XIV зууны сүүл хагаст хятадаар галиглагч бээр хэр зэрэг зөв уншсан бол? гэх зэрэг асуултыг анхааран судалдаг болжээ.

舌, 中 болон 克, 勒, 黑, 惕, 卜, 木, 赤, 思, 𐪞, 你, 室, 先, 𐪟, 乞, 𐪟, 𐪟, 𐪟, 𐪟 тэмдгийг хэрэглэн гийгүүлэгч үсгийг сэлгэн унших, дэвсгэр үсгийг ялган тэмдэглэсэн нь бидэнд үсгийг зөв дуудан уншихад тус дөхөм болж байна. “Монголын нууц товчоо”-г галиглахад хятад үсгийг зохион хэрэглэсэн болон утга зүйн үүднээс шинээр зохиосон үсэг олон байдаг нь хятад бичгийн эрдэмтдээс гадна монгол бичгийн эрдэмтэд ч гол үүрэгтэй ажиллаж байсныг харуулж байна. Авиа зүй, утга зүйн хувьд бичгийн бүтцийг үндэслэн галигласан хятад үсэг олон байна. Энэхүү